



ХАМНИГАН СУДЛАЛ

Хамниган
Судлал



ХАМНИГАНСКИЕ ИССЛЕДОВАНИЯ

ЧӨЛӨӨТ СӨНИН

№001

2020.08.21

ХАМНИГАН АКА ДҮҮ НАРТУ БОЛОН КҮНДЭТ УНШИГЧИД ТАНДУ

“Хамниган судлал” хэмээх сонин бичиг бичибэрийн экзний дугаарыг уншигчи танду, анку удаага өргөн баригу байнавида.

Цаарусан дээр хамниган кэлээрээ мүрэ үлдөөжи, сонин бичибэр кэблэжи гаргаху ану хамнигадын түүхийн чикул кэрэг ябудал билээ.

Хамниган угсагатны экэ түүкэ, соёул, ёсу заншил, угсагатны зүй (этнографи) судлулыг мөнөгөө цагту олунду таркаан таниулакын төлөгө Хамниган судлулын түб болон эрдэмтэн багши нар, судлаачид, олун нийтийн ажил ябуулагчид хамтуран бүхий олун түмний тусу дэмтэйгээр хамниган кэлээр сонин бичиг, бичибэр гаргакар зориглон икэ л мэрийн, чирмайн ажиллажу байна бида. “Хамниган судлал сонин бичиг, бичибэр”-ийн гол зорилго ни хамниган арду зоны, хамниган угсагатны кэлэ, түүкэ, соёул, угсагатны зүйн талаарка шинэ соргого мэдэгээг арду зонду күргэжи, хамниган судлалыг көгжүүлэхэд тус дэмжилгэ үзүүлэхэдэ оршиху амой.

Хамниган кэлээр бичикэ ни одогоо цагту бэлэн кэрэг бишэ, гэбчиги өөрсдийн кэлээр коорондоо көөрөлдөж харилцаку ни тун кэрэгтэй гэжи бидэнэр ойлгожи, түүнийгээ ч мэдэрчи байнавида. Хамниган кэлээр сонин гаргаху энэ шинэ түсэлийг биелүүлэнэ гэдэг тун икэ хариуцалгатай ажил мүн бөгөөд энэ тукай кэлэ бичигийн ухааны доктор, хамниган судлагач Д.Г.Дамдинов “хамниганаар бичикэдээ чинга дүрим баримталха гэжи зовох кэрэггүй. Энэ бидэний коорондоо харилцака, өөрсдөө мэдэхэ асуудал мүн” гэж кэлэсэн ни бидэ бүкэндэ урама зориг өгөсөн ябудал болсныг эндү онцолун тэмдэглэн хэлэк ни зүйтэй юм.

Хамнигадын түүкэ, кэлэ яриа, угсагатны талаарки эрдэм шинжилгээний судалгааны бичибэрүүд мөнөгөө цагту монгол, орос болон дэлэкэйн бусад кэлээр нийтлэгдэж байгааг бидэ али ч кэлэн дээр ни уншиж танилцажу байгаа кэдий болбочи, гэбчиги



бидэ коорондоо хамниган кэлэ аялгуугаар ярилцажи, бичилцэжи чидажу байка ёсутойвида.

Оросын буддын шажины тэргэгүн Сангхын Бандида хамба ламу Дамба Аюшеевын дэмжилгэтэйгөөр энээкэн сонин бичиг, бичибэр ману анк удаага кэвлэгдэн олун түмний күртээл болун гарчу байгаагийг бүхий уншигчи зонду дуулгакад нэн икэ таалалтай байнавида. Хамниган кэлээ сэргөөкэ бидэний ажулыг дэмжигөөж, мүн буриасуудын бүхий кэлэ аялгууг сэргээхийн түлүгө Дамба Аюшеев хамба ламу идэбки санаачилга гаргун ажиллаж байгаа ба өөрснийнөөн үүсгэн байгуулсан “Буриад ФМ-радио”-д хамнигадын тукай радио нэвтрүүлэг дамжилдаг болсун ни эгүүний тоду илэрхийлэл ни болжу байна. Бидэ одоокондоо өөрснийнөөн эзэмшисэн хамниган кэлэ ярианы түбшинд сарду коёр удаага хамниган кэлэ аялгуугаар радиогийн эфрийн нэвтрүүлгэ бэлдэж чидажу чинээнийнөө кэмжээнд хамниган кэлээ олунду күргэж эжилээд байнавида. Хамниган арду зоны ману радио нэвтрүүлэгт

өгсөн кэлэ яриа, дуулсан дуу куур, өдүгөө цагийн цахим юртэмц интернетээр икөөкөн таражи байна. Мөнөөкөний энэ цаг дору хамнигадын кэлэ, түүкэ соёлыг ману өөд ни үргэлцэжи буй Хамба ламудаа бидэ гүн таларкалаа күргэнэвида.

21-р зуунд дэлэкейн күн зон глобализацид оржу угсагатан коорондын ижилсэл курдацтай явагдаку болов. Энэ бүкэнтэй эсрэгцэн үндэр күгжилтэй улас орнууд угсагатаны өвөрмөц илгарал дээр анкаарлаа кандуулж соёл, урлаг, аялал жуулчлалын бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг күгжүүлж күгжлийн шинэ чиг хандлагийг бий болгожу өөрсү коорондоо илгарах илгарал, шинэ содун зүйлээр үрсэлдижи соёл, урлаг, аялал жуулчлалын күгжлийн бодлого баримтлаку болов. Энэ бүкэ күгжлийн чиг хандлагатай уялдаж хамнигадын бусдаас илгарах илгарал мүн тэдөөний давтагдакагүй өрмөц онцлогийг олун түмэндэ сурталчилан таниулак зорилготой “Хамниган судлулын түб” 2015 онду Улаан-Баатар хотуд байгуулагдажу тэрэ цагаас экэлэн хамнигасын тукай

мэдэгээ, мэдээлэл икээкэн илэ тоду яригдаха болжу олун түмэндэ күрч эжилсэн тула бидэ ч гэсэн хамниган кэлэ яриагаа сэргээкэ талу дээр тэдөөнтэй хамтуран ажиллаж мөнөгөөдөрийг күрчи ирээвидэ. Байгуулагдсан цагаас койши мөнөгөө болтол Хамниган судлалын тус түб амжилттай ажиллаж ирсэн ба өөрсдийнөө ябуулж буй үйлэ кэрэгэ, зокион байгуулсан томоокон ажилнуусыг олун нийтийн цахим интернет сүлжээгөөр дамжилулан дэлэкейн өнцөг булан бүрид амьдран буй күн зонду күргэн танигуулах ажилыг эдибкитэй ябуулжи байна л. Тэд мөнөгөөний күн зоны идэвкитэй кэрэглээ болсун Фейсбүүк, Вайберчат-ийн хамнигадын колбоосуудыг бий болгоод байгаа ба, Өвөр Монголын хамнигад Вичат (WeChat)-ийн социал олон нийтийн сүлжээний колбоог мөн бий болгож тэдэ өөрсөд коорондоо шууд ярилцаж, шинэ сонин мэдэгээг бие биесдээ дамжилуулж идэбкитэй карилцадаг болсун байна.

Анклан тэрэгүүн болжи гарчу буй “Хамниган судлал сонин бичиг, бичибэр” ману хамнигадуудын кэлэ яриа, хамниган угсагатны өвөрмөц соёл, ёсу заншилийг сэргээжи, тэдөөний өвөрмөц онцлогийг олунду таниулкада кэрэгтэй ажил болок акул дө гэжи бодоном.

Хамниган арду та бүкэн ману бултаараа экэ кэлэ, соёул, ёсу зан заншилаа сэргээкэ энэ икэ ажилда ману идэбкитэй оролцожи, үбэ соёулоо күүгэд залуусиддаа өвлүүлэн дамжилуулж, өөрийн уламжлалт шивхагдашгүй икэ соёулыг модернизацлаж орчин үеийн бүтээлчи үйлдвэрлэлийн салбарту амжилт гарган 21-р зууны күгжилтэй күл нийлүүлэн урагштай алкай кэмээн уриалиж байнавида.

**Хамниган Судлалын Төвийн Удирдах
Зөвлөлийн Дарга
Хатагин Хамниган овогт С.Мөнхжаргал.
Гүнээкин овогт Бадмажаб
Гындынцыренов, сонини эрхилэгч
(редактор)**

ХАМНИГАН И ДОРОГИМ НАШИМ ЧИТАТЕЛЯМ

Мы представляем вашему вниманию первый номер газеты «Хамниганские исследования».

Впервые в истории выходит газета на хамниганском диалекте бурят-монгольского языка. Это действительно значимое событие для хамниган, как составной части бурят-монгольского народа. В целях изучения вопросов языка, культуры и этнографии хамниганы их распространения Центр хамниганских исследований совместно с деятелями науки и культуры начал работу над этим периодическим изданием. Читать и писать на хамниганском языке не так просто, но мы глубоко осознаем всю важность общения на родном языке. И поэтому путем проб и ошибок намерены издавать газету.

Отрадно, что доктор филологических наук, автор многих статей, книг и словарей на хамниганском языке Д.Г. Дамдинов поддерживает идею создания газеты. Его советы воодушевляют нас к воплощению наших планов.

Выражаем признательность Хамбо ламе Дамбе Аюшееву за поддержку и понимание в возрождении языка и культуры хамниганского народа. Благодаря ему звучит хамниганская речь в эфире радио Буряад ФМ, и сейчас в свет выходит газета на хамниганском языке.

Призываем всех сородичей хамниган не оставаться в стороне от наших дел и внести свой посильный вклад в дело сохранения и развития родного языка, культуры и традиций.





“ХАМНИГАН СУДЛУУЛЫН ТҮБЭ” ТББ БАЙГУУЛАГДСАН ТУКАЙ ТОВЧИ ТАНИЛЦУУЛГА:



XXI зуунда глобализаци эрчимтэй явугдаж дэлгэж хүн төрлөктөн техникийн дэвшил, мэдэгэллийн технологийн күгжлийн нөлөөгөөр хотжилт эрчимжиж суурин иргэншил давамгайлах болж, хүн амын амьдралын кэбэ маяг курдацтай өөрчилөгдөж буй өнөө үед үндэсний өбү соёлоо дээдлэх замаар соёлын бүтэцээ үйлдвэрлэл (инноваци, креатив), хүнийг хөгжүүлэхэд дэлгэж улс орнууд төдийгүй Монгол улс ч мүн анхаарлаа хандаж байна.

Төрөөс соёлын талаар баримтлах бодлогод “Монгол үндэсний соёл нь монголын ард түмний оюуны суурь дархлаа, өвөрмөц дүр төрхийн тодорхой илрэл, гурван цагийг холбосон ариун нандин холбоос мөн. Монгол Улсын төр XXI зуунд улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээнд соёлын талаар баримтлах бодлогоо өргөжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна” хэмээгээд соёлын талаар баримтлах бодлогын зарчмын 3.1.3.–д “монгол үндэстэн, үндэстний цөөнхийн өв соёл, түүх, ёс заншлыг тэгш хүндэтгэн, хадгалж хамгаалах” хэмээн заасан байдаг билээ. Энэхүү бодлого чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаар “Хамниган судлалын түбэ ТББ” Монгол Улсын нийслэл Улаганбагатур хотод 2015 онд байгуулагдсан бөгөөд Төрөөс соёлын талаар баримтлаж буй “монгол үндэстэн, үндэстний цөөнхийн өв соёл, түүх, ёс заншлыг тэгш хүндэтгэн, хадгалж хамгаалах” хэмээх бодлого чиглэлтэй уялдаж байгаа юм. Хамниган Судлалын Түбэ нь Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын үндэсний сурын дархан мэргэн, гавьяат тамирчин Ц.Хүдэрчулуун болон Р.Бадрал, С.Мөнхжаргал, Л.Ганбаяр, Ж.Хүрэлбаатар гэсэн таван хүний бүрэлдэхүүнтэй удирдах зүвлөл байгуулагдсан ба олун нийтэд үйлчилэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

ХАМНИГАН КЭЛЭ АЯЛГУУНЫ ТУХАЙДУ:

“Хамниган угсаатны түүх, кэлэ соёлын талаар судалгаа кисэн эрдэмтэн олун бишэ болбучи тэдгээрийн дотороос академич Б.Ринчины Монгол Хамнигасыг гуч илүү жилэ судлан бичигсэн “Монгол Ард Улсын Хамниган Аялгуу” хэмээх нигэ сэдэвтү бүтэцээ икэ чикул судалгааны бүтэцээд тооцогддог. Уг бүтэцээд “Хамнигадын ярьж хэлж буй хэл яриа ихэд сонирхолтой дундад эртний монгол хэл аялгууны зарим элементүүд эдүүгээ ч хадгалагдан байгаа нь хэл судлаач хэн бүхний сонирхолыг ихэд татхаар байна” хэмээгэсэн болу, академич Л.Мишиг “тэдний одоогийн хэл аялгуу нь монголын нууц товчооны хэл буюу дундад эртний монголчуудын хэлний онцлогийг хадгалсаар байгаа ажээ” хэмээн кэлэ шинжилгэлийн коёр икэ эрдэмтэн онцолун тэмдэглэн үлдэгээсэн ни икээхэн сонирхолтой юмэ. Иймдэ “Хамниган судлалын түбэ” ТББ ни эдгээр эрдэмтэдийн кэлжи бичиж тэмдэглэн үлдэгээсэн дундад эртний монгол кэлэ аилгуугаар яригчи тэдгээр өбү тээгчид хобурдожи, мартагдажи, устажи буйг анхааралдаа абчу тэдгээр өбү соёлыг залагуу хойчи үедөө өблүүлэн үлдээхээр ажиллаж буй ни зөвкөн “үндэстний цөөн”–ийн түүх, кэлэ соёл, ёсу заншилыг хүндэтгэн, хадгалаха хамгаалаха ажил төдийкөн бишэ, “монгол үндэстэн”–ий өбүгэ монгол кэлэ соёлын уламжилалту икэ өбийг авчи үлдээхээр ажиллаж буйн илэрэл юмэ. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд үнэтэй тус дэмэ болно хэмээн үзэжи “Хамниган Судлал сонин бичбэр”–ийн экэний дугаарту икээхэн ачи холбогдол өгчи идэбхи зүтгэл гарган ажиллаж байнавида.

Хамнигасын талаар судалсан судлаачид нилээд кэдэ кэдэ бий болбучи экэний удагаад дараах эрдэмтэд болон тэдгээрийн бүтэцээлүүдийн талаар онцолон абчу үзье.

1. Эрдэмтэн Ц.Жамцарано 1911 онд Ононий Хамнигасын дунда аман мэдэгээ цуглуулсан ака. Төрэни Санкт-петербург хотын “Восточных Рукописей”–гийн сан көмрөгтү хадгалагдан байсуныг буриасай эрдэмтэн Л.Шагдаров, Ц.А.Дугар–Намаев, Д.Г.Дамдинов нару кэблэлдү бэлтэгжү 6 үлгирийг Хамниган кэлэнээс орчуулан Хамниган, Орос кэлээр 1982 онду кэбэлүүлсэн юмэ.

2. Академич Б.Ринчен Монголын кэдэ кэдэн нитугийн Хамнигасуудыг гуч илүү жилэ дагнан судалжи “Монгол Ард Улсын Хамниган Аялгуу” хэмээх бүтэцээлээ 1969 онду туурвилсан билээ. Б.Ринчен “Хамниган” гэдэг нэрийн гарал үүсгэлийн талаарка өөрийн тодорхой саналыг дэвшигүүлээгүй болбучи АНУ–ын эрдэмтэн Ф.В.Кливицийн судалан анка дэвшигүүлсэн эртний Кавканас овгийн нэрэ сунжирчи Хамниган хэмээхэ болсон байка гэдэг саналтай нэгдэж тэгүүний саналыг дэмжижү байсан юмэ.

3. Д.Г.Дамдинов, Хамнигадын талаарки дагнан судалагчидын дотор Буриасын эрдэмтэдээс нилээгээд онцгойрсон хүн гэжэ болно. Төрэ Ононы Хамнигасын угсагаа гарбулыг судлагдаа бусад судлаачидын бүтээлийг шүүрдэн зарим нигэнд ни үнэлэлт дүгнэлт өгөхийн зэрэгцээ өөрийн саналаа нэлээд бодитой, чилөөтэй, өгүүлсэн билээ. Д.Г.Дамдинов өдүгөө Хамниган Тунгус (Эвенк) гэдэг ойлголтыг адилканаар боддог болсон ни тиймэчи гайках зүйлэ бишэ юмэ. Учир ни гээбэл, Хамнигасууд түүхийн олун жилийн цаг хугацааны ябуцад Сибирийн олун ястангуудтай көрши зэргэлдөө ажүтөрөн амидаран суукадаа тэдөөний зарим нигентэй ни ураг барилдан голдуу ан амитантай холбоотой үгэ кэллэг, зарим кэлэ ярианы болон акуй амидаралын ижилсэл явугдасны нигэн тоду илрэл болу Эвенкийн ортон, орчоон, морьчин, мөрчин зэрэг обугууд юмэ. Мүн “XVII, XVIII–р зууны үеэс Европ дакинаа Сибирийн олун жижиг угсаатнуудыг Тунгус хэмээн нэрлэхэ нэршил бий болжээ. Тунгус хэмээхэ нэршил дору Хамниган, Эвенкүүд болон Сибирийн бусад жижиг угсаатныг хамруулан ойлгоко болсон ни нэн харамсалтай бөлгөө” гэжээ.

Тэрэ өөрийн саналыг дэвшигүүлэхдээ Хамниган гэсэн нэрэ эртэний Киданы нигэн отогийн нэрэ байсан бололтой. Ононы Хамнигасуудын нутаг уул, моду икитэй тул бусад монголчуудаас оорцоого тасархай байсан тул эртэний монгол кэлээ удатал хадгалан үлдсэн юмэ гээд Байгал орчимын Тунгус, Дагуур, Буриасууд тэдэ хамтаран нигэ дору хэсэг байснаа хожим ни сүрхий икэ салжи сарнин одусун тукай зарим ни зүүн тийшэ тэрэгидэсэн (Хар мөрүн), мүн Хамниганы нэлээд хэсэг нь Монголын Ерөө голын орчим суурьшсан тукай зэрэг түүхэн баримтаар бичисэн юмэ. Г.Дамдинов хамниганы кэлэ шинжилгэлийн онцлого Ононы Хамнигасын угсагаа гарбулын талаарки Дорнод байгалийн Хамнигасын өнгөрсөн одоогийн талаар мүн Армакийн Хамнигадын тукай зэрэг олун асуугуудыг боловсруулан судалгааны эргэлтэнд оруугуулан бусдын хүртэгээл болгосон билээ.

4. Гадагаадын судлаачдын Хамнигасын талаар судулан тэмдэглэн үлдэгээсэн зүйлийн талаар товчи өгүүлье.

- Хамниганы нүгүдэл сууришилын талаарка цөөнгүй эрдэмтэдийн нэгдмэл бус судалгаа байдаг ба тухайлбал, К.В.Вяткина тэднийг 300 жилийн өмнө Монголоос гарч ябусан гэдэг,

- Монголчуудын түүхийг судалсан өрнүдийн ихэнкэ эрдэмтэд эрхлэхэ ажү акуйтай ни холбогдуулжи Ойн иргэд гэдэг ангилал тогтоогоход нэртэ эрдэмтэн Б.Я.Владимирцов ч багагүй нөлөөгө үзүүлсэн билээ.

- Үнэхээр Хамнигасын ажү акуй, хувцас, ан агнуурын байдлаас үүдэн угсаагтан судлаач, түүхч Л.Л.Викторова Х–XII зууны үеэс Ононы Хамниган Урианкай овгийнхон лавтай байсан гэдэг нь тэднийг Хамнигад ойн иргэд гэдгийг батлахын зэрэгцээ тэдний овгийн шүтлэгийн талаарка нэлээд анхааран судалсныг тэмдэглэвэл зохино.

- И.М.Золотарева ХХ–р зууны экээр Ононы Хамнигасын дунда хүн судлалын (антропологи)–ийн кэмжилт кижү тэдэнтэй Тува, Агын буриасын шинжи байдал нэлээд төстэй гэсэн дүгнэлт кисэн ни тунгус гэгдэн хэлэхдэхэ болсон хамнигас тэдэнтэй угсагаа гарбул нэг бус гэдгийн тоду илэрэл, мүн тэдэ газар зүйн хувьд XVIII зуунаас ч өмнө тува, урианкай, хамнигас, монголчууд хамт нутаглаж байсныг ни ч харуулаж буй бизэ.

- Өрнүдийн эрдэмтэдээс Мажарын (Унгарын) Уран Кехальма Хамнигасын кэлэ шинжлэлийн судалгааг Хэнтийн Дадал суманд 1950–аад оны сүүлчээр хийжү Манжу, Монгол Тунгус кэлэний илгаа, онцлогийг гаргаха оролдлого хийсэн юмэ.

Өнгөрсөн түүхийг сөхөн харабал Хамнигас түбэ азийн өндөрлүг дэхэ талын нүүдэлчидийн нигэн адил өнгөрсөн түүхийн хутгалдаан нугачиан дунда чухам ямар ула мурэ үлдээн хаагуур, ямаркуу ябусаныг көрши зэргэлдээк орнуудын түүхэн бичигийн экэ сурбалжи, түүхэ архивын материал зэргээс эржи шүүн олжи судалгаа шинжилгэ кижэ ни икэ чухал ажил болоод байна. Бидэ өөрсөдөө энэ цагту идэбхи зүтгил гарган түб азийн нүүдэлчидийн дунда бидэний өбүг дээдэс Хамнигадууд кэн байж бэ гэдэгийг судулан тогтоож мэдэж абуха үгүй бол Хамнигасуудын дээдэ угсагаа гарбулын талаар урид өмнө ни кисэн зарим судлаачдын хэтэ нигэ талыг барисан алдага мадагтай судалгааны дүгнэлтүүд одоочи энэ цагту уламжилагдан үргэлжилэхэ мадагтай байна. Энэ мэтэ зарим эрдэмтдийн алдаа мадагтай дүгнэлтийн улмаас угсаатны укамсар доройтон гадуурхагдаж “ би хамниган хүнби” хэмээн өөрийгөө нэрлэхэ хүн цөөрсний улмаас Хамниган судлал, Хамниганы үбэ соёл, Хамниганы экэ сурбалжи, Хамниганы үгэ кэллэг цөм өнөө цагту бичигдэж яригдах үгүй мартагдаха болсон тул угсагаа гарбул, экэ түүхээ эргэн харжү шинжилэхэ ухааны үүдэнээс түүхийн үнэнийг судлан тогтооко хариуцлагатай цаг ирээд байна. Абу ижигөө бидэ сонгодоггүй энэ бол хүний заяаг дмал хуби тавилан юмэ. Тиймээс аливаа хүн өөрийн угсагаа гарбулаа судлан таниха эрхитэй хүн үүрэгтэй, тиймээс угсаа гарбулаа судлан таниха ни бидэний чин хүсэл, бидэнд тохоон олгугдсон түүхэн үүрэг, түүхэн укамсар билээ.

Агуу икэ хүнүкэ күкэ тэнгэр та бидэнийг өнө хүнүкэд ивэгжэ сайн үйлэс бүхэн дэлгэрэх болтугай.

Мүнкэ күкэ төнгөрийн дору ажү төрөн суугаа элгин садун, ураг төрөл, угсаагаа гарбул нигэтэй Хамниган акан дүүсэ та бүхэндээ “Хамниган судлал” сонин бичбэрийн экэний дугаар күрчи очик бэлигтэй, кура бороо икэтэй зуны дэлгэр сайкан өдрийн мэндийг өргөн дэвшүүлбэби.

ХАМНИГАН СУДЛАЛЫН ТӨВИЙН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
ХАТАГИН ХАМНИГАН ОВОГТ С.МӨНХЖАРГАЛ



ОТКРЫТОЕ ОБРАЩЕНИЕ ГУБЕРНАТОРУ ЗАБАЙКАЛЬСКОГО КРАЯ ОСИПОВУ А.М.

Уважаемый Александр Михайлович!

В целях сохранения и развития языка и культуры хамниган Забайкалья в 2021 году состоится II фестиваль хамниганской культуры в селе Гунэй Агинского бурятского округа.

Организаторы фестиваля обращаются лично к вам, в Правительство Забайкальского края, с просьбой оказать организационную и финансовую помощь в проведении данного мероприятия.

А также в целях возрождения языка и культуры хамниган-коренного народа Забайкалья вносим следующие предложения:

–создать условия для изучения хамниганского языка и культуры в местах,

где компактно проживают хамниганы (разработать авторскую методику изучения хамниганского языка и культуры на базе Тарбальджейской ООШ Кыринского района);

–создать фольклорные ансамбли хамниган в селах Тарбальджей Кыринского района и Токчин Дульдургинского района;

–образовать центр традиционной народной культуры Приононья в селе Гунэй Агинского района (направления деятельности центра:изготовление войлочной юрты, выделка овчины, пошив национальной одежды);

–издать эпические произведения олонских хамниган, записанных ученым Ц. Жамсарано в 1911 году (материалы хранятся в Архиве Санкт-Петербургского отделения

Института востоковедения РАН);

–издать хамниганский словарь (составители д.ф.н. Д. Дамдинов, глава СП МО «Курулга» Акшинского района М. Сариева, журналист, переводчик Б. Гындынцыренов);

–издать сборник хамниганских народных песен.

С уважением,

Дамдинов Дашинама Галданович, доктор филологических наук, ветеран ВОВ, уроженец с. Токчин;

Семенов Валерий Шойжамсоевич, председатель Совета депутатов МОСП «Гунэй» Агинского района, ветеран педагогического труда, краевед;

Гомбожапов Арслан Гармазиевич, кандидат исторических наук, старший

научный сотрудник Института филологии СО РАН, (г. Новосибирск), уроженец с. Гунэй;

Сариева Манидари Галсановна, глава Администрации МО СП «Курулга» Акшинского района;

Дармаев Рихард Цыдыпович, глава Администрации МО СП «Гунэй» Агинского района;


Данзанова Надежда Ивановна, глава Администрации МО СП «Токчин»;

Гындынцыренов Бадмажаб Валерьевич, корреспондент республиканской газеты «Буряад унэн» (г. Улан-Удэ), журналист, уроженец с. Гунэй;

Ламажапова Марина Доржиевна, учитель Тарбальджейской ООШ Кыринского района.

Январь 2020 г.

МИНИЙ ӨВӨӨ



Залуу калуун насундаа Забайкалийн хасак цэрэг ябусан. Тэрэ үед манайканы бүхий л хамниган залуу эрэгтэйчүүл ни булту хасагууд байсан –ака. Тийгөөд л Забайкалийн хасаг полко–д албунду тэдөөнтэйгөө камту ябулцаа–асун байена.

Өвөө мана 1914 оноос 1917 ону күртэл нэгидэки дөлөкэйн дайндү үеэ тэнгийн нүкэдтэйгөө камту ябулцаад, тэндэ дайтуж яваад ирөөсөн. Бүри жаалакан күүгэд байкудаа дацунду кубараг байгаа. Ульхун–Партиду Күшүүрийн дацунду кубараг болоод, тийгөөд л цаашиэ Цүүгүүлийн дацундучижи, жируг зуржи сураад , буркан жирудаг жиругчин, эмчи ламахайболоо. Олон бурканы күриг зуржи, алтун үсэгөөр Доржи Жодобо ному бүтөөжи Агын дацунду өргил болгоо асан. Мүнөө чиги өвөөгий минни бүтөөсэн буркан, ному ни байна. Ламу күн байсан гээд 1933 онду өвөөгий минни баривчилаад цүлүлгэндү одулжи оркиосан, тийгөөд л дайн өнгөрөтөрни тэндү

цүлүлгүндэ байсан акулдө. 1945 онду гэртээ буцажи ирөө, дакин цүлүлгэндү абтахааса, засуг куулиаас икэ айдуг асан. Тиймэчи гэсэн аасу бурканы ному үзүсэн эмчи ламу асан акудаа ниуцаар күнийги эмчилжи аргалагчил асан дөө. Өөрийн кисэн эмээ л икэ нуудаг асан.

Би өвөөгийнгөө яригсанасанаас ни бага сага юма мэдэчки асамби. Ламу акуудаа олон күндү нэрэ үгөө. Хамнигад ману күүгэдтэй болокодоо өвөөд ману ирэжи, күүгэдтөө нэрэ гуйкчи асан. Дацун ойро үгүй, ламнар коло, тийгөөд манайду күн зон ирэжи, адис арушаан авчи, күүгөсөө адислуулаад, нэрэ гуйжи ябугчсан. Тийгөжи л олон күний багши ни болоосон до өвөө ману. Миний коёр дүүгей нөрийн өвөө ману өгөөсөн, тэдэнийг – Долгорсүрүн, Долгоржав гэдөг. Миний нэр Дарисүрүн, нүкэрийн минни нэр – Гомбодорж.

Өвөө ману икэ сүркий, чидалтай, буянтай ламу байгаа – күндү мийн ла цай үлээгөөд үкүдэни тэрээнийн кэргэлсэн өвчинтэй күн,

күүгэд эдэгэчи асан. Тэрөөнийг ни би сайн мэдэгчи байгаави, икэ маани уншидаг, буян кидэг асан. Заримдаа икэ юма ярикчи асан. “Нигэ дүчээд жил өнгөрүдү цөвүүн цаг болку, янзу бүрийн күний мэдэкэгүй өвчин бий болку. Таанар минни тиймү юма үзэкү болкута. Икэ буян кикү кэрэгтэй болку. Буян кинүгүйгээр өөдөлөкүгүтэ күүгэд минни” гэжи яридаг асан. Тэрэ кэлэсэний ни мүнөө бида нар үзэжи, каражи, заримдаа мэдэжи байна вида. Янзу бүрийн юма мүнөгө болжил байна. Өвөө ману миний багши минни, намутай үе тэнгийн күн шингээр заримдаа найзулдагсан, дуудак нэрийг минни үгсэн, бурканы тукай, буян кикэ тукай, мөн маани уншикийг заагаасан, икэ хайртай күн минни. Өвөө мону 1969 онду 82 насундаа насу бараасанда, көөркий мину.

Дарисүрүн Гармаева.
Ульхун–Парти

Миний өвөө (өбүгөө) Цемпилов Доржи Натарович 1888 онду Ульхун–Партиду ламу күний гэр бүлэдү түрүсэн ажигу.

КҮН ЗОНЫ ТОО ТООЛОЛГО 2021 ОНЫ АПРЕЛЬ САРД БОЛОХУ



Орос гүрэн даяар күн амын тоолооны үедэ ямар кэлэ мэдэнэ, түүнийгээ кэр зэрэг кэрэглэнэ бэйта гэсэн асуулгандү карюу кэлэкэ кэрэгтэй болохо. Камта дээрээ 23 асуулга күнүүдтэ тавигдаха юма. Нас, иргэншил (гражданство), түрөгсөн газар, үндэс угсага, ясны камаарал, боловсрол, гэрлэсний байдал, күүгэдийн тоо, каанаас мөнгө оложи амидарна бэйта, ямар ажил кидэг вэ гэкэ мэтэ асуулта явагдаха.

Таны гэр байр байдалын тукай басал сураглана – ямар гэрт байна бита, таны гэр кээзэний цагту баригдасан вэ, гэрийн хана ямар материал вэ, кэдий талмытай вэ, болбосон түкэлдэ оруулагсан уу гэсэн асуудалуудта карюу баса өгөх кэрэгтэй.

Орос улсын газар дайдаду цаг зуура ирэж байсан гадаад ороны күнгүүд 7 асуултандү карюулна: хүйс, нас, ямар гүрэнөөс ирсэн, Орос улсад ирсэн зорилого, Орос уласту ирээсэр кэрэ удаан байсанаа, төрсөн гүрэнөө, ямар иргэншилтэй байсанаа кэлэжи үгэкэ юм аа.

2021 оны күн амны тоололын програмаду зарим асуулаганууд шинэчлэгдсэн байна. Орос кэлэ ба ондоо ямар кэлэнүүшийг мэдэхээс гадна өдөр бүрийн

амьдаралдаа тэрэ мэдэкэ кэлээ кэрэ зэрэг кэрэглэнэ бы та гэж асуужи сонирхоцоогоо болоно. Эндэ абтасан карюунууд боловсорол сургалтын програмууд тэдөөндө кэрэ зэрэг ашиг тусаа өгчи байгаа ба үндэс ястануудын сургуулинуудта кэр кэрэгтэй байсаныг цэгнөкэд туса болохо юма.

Орос гүрэний күн амын энээкэн тоололгонд кэдэн аргаар оролцож болоно. “Госуслуги” гэсэн порталд орж, анкет бөглөхөд болно, тоололгоны стационарна участогуудад, “Мои документы” гэсэн гүрэний ба нютаг орны засаг закиргааны үйлчилгээ үзүүлэхэ түбүүдтэ болон али эсбэл гэртээ тоологч күнийг ирээкийг күлээж, гэртээ байгаад асуултануудта карюулакад болохо юм байна.

Хамниган та бүкэн өөстийгөө хамниган үндэс ястан гээд тэмдэглэхэд болохо юм байна. Хамниган кэлэ мэдэнэви гэжэ баса л кэлэхэ кэрэгтэй. Тийгэжэ байжли хамнигадын байдаг нитугуудта хамниган кэлэ заака үндэс ни бий болж өгөкө гэж ойлгож болоно.

Буряад Улсын Засагы газары сайтын мэдээгээр
Бадмажаб Гындынцыренов бэлдэв.



ОРОС УЛСЫН ХАМНИГАДЫН АМЬДАРЧ БУЙ НИТУГААР АЯЛАГСАН ТЭМДЭГЛЭЛ

(2019 он)

К вашему вниманию представляем статью профессора Хулэн-Буйрского института Внутренней Монголии КНР Ж. Цэндэм «Путевые заметки по местам компактного проживания хамниган Забайкалья».

Хамниган угсаатны түүх, кэлэ соёлыг байцаан шинжилэх (асууж лабла) зорилгоор 2011 оны намар судалгаа кийгээд, үнгэрэгчи зуны үеэр хоёр дахи удаагаа Оросын хамнигадын нитугаар аялаба. Цаг хугацаа, кэлэ яриа зэргэ олон талын хизагаарлалтаас болж байцаан сурбалжилгад мана үдүй төдий саад тохиолдож байсанчи чимналт үгүй олзотой буцацгаасан юм. Адали биш нитугаар таран суугаа хамнигасаас түүж цуглуулсан түүхэ соёлд холбогдох олзыгоо кэлхин холбоод уншигчид таны караанд дэлгэн барилаа.

20 дугаар зууны экеэн үеийн нийгэмийн үймөөн тэбчээн, дайн дажинаас болж Орос улсад суугаа хамнигас өөдэ уруугаа нүүдэллэн нитуг шилжих ба цаашилбал, улсын хилийг даван суурьшижсан байна ака.

Кэдий май нүүдэл буудал болоо гэж болбачу үнэнийг кэлэкэдэ, тэдэнэр ороггүй холо газар түриж ябацагаасан биш, мүн лэ эрт дээр үеэсээ нүүдэллэн ажу түрж байсан нитугийн хэмжиеэнээс гарсан үгэй гэсэнч болох юм аа. Одоохондо Оросын хамнигасын таран суугаа нитуг гэвэл: Өвөр Байгалийн кизгаарт түблэжи байна. Бодитоор кэлвэл, Өвөр Байгалийн кизгаарын Могойтын аймаг, Дулдаргын аймаг, Агын аймаг, Шилкын аймаг, Карымскын аймаг, Кэрийн аймаг, Акшаагын аймаг, Ононы аймаг зэрэг аймаг сомонуудаар сууж байна.

ХАМНИГАДЫН ТОО ОЛХОД БЭРХЭТЭЙ

Орос уласту хамниган угсаатны хүмүүсийн тоо баримтыг олход бэрхэтэй бодогдоно. Яагаад гэвэл, нигэдэ, хамниган хүмүүсийг “хамниган”

гэдэг нэрээр бүридгэж дансалдаг үгэй,

хоёрто, олонки байдалд хамнигад тасархай бутархай хэлбэрээр голчилон орос, буряад үндэстэн ястантай холилдон сууж байна,

гурвада, оросын хамнигадыг эвенк, буряад, орос гүүчилэн адали биш угсаа ястанаар бүридгэн тэмдэглэж байсан үе ч байна,

дүрвэдэ, хамнигадта багтах үгэй угсаа ястан бас “хамниган” гэжи ташаа нэрлэх үзэгдэлч байна,

тавада, хамнигад гуучилан буряадчууд гээд оросчуудын урт хугацаагаар барагцаалан ярисани доорохи мэдээ:

Зугаалайд 100–гаад, Тугчинд 400–500–гаад, Куралга Нарасунд 100–200–гаад, Үзөөнд 100–200–гаад, Тарбалжид 150–200–гаад, Гүнээд 150–аад, Алтанда – 50–аад хамнигад бий.

Тэгвэл, Бооржоор байдаг ни бараг хамниган гэдэг түүхийг бүрэг бараг ойлголтоотой болж байгаа бизэ.

Шилкын хойто бие Нарин нитуг, Үрэлэнгэ, Түүргэ, Бооржоор хамнигад байгсани мэдэкэ болбач күний тоо бараглаж чиха үгэй л байлаа. Дээрхи тоонууд ни таамаглал болбач хамнигадын одоогоор суугаа нилээд түблэрэнги нитугийн илэржэйлж байх юм аа.

Ононы хамнигад ба Шилкын хамнигад 2011 оны намар оросын хамнигасыг сурбалжилан явах зуураа, Агын музей тааран үзэбэ. Музейн тайлбарлагчидта явж байгаа учираа дурдаж сураг занги олоко юу магад хэмээн горидба. Күсэл маан талагар болсон үгэй. Бидэнийг музейн дарга Гармажаб Батужиргалтай танилцуулж үгвэ. Батужиргал даргаас хамнигадын сууж байгаа нитугийг мэдээд, хамниган настаны нэрийг дурдаж уулзахыг сануулба.

Тэрэний ярианаас Оросын хамнигадыг «Ононы хамнигад», «Шилкын хамнигад» гэж хуваан үзэдэгийг анхааран соносогсон ба бүхий хамниган угсаатани ийгөж хуваах ану тэдэний бодит байдалтай нийцэхээр бараха үгэй хамниган угсаатны түүхэ, кэлэ, соёлыг мурдэн судалхад нигэ алхам түхэм дүтэ болгох үйлэдэлтэй гэсэнийг мэдэрэгсэн

билээ.

Гүнээ, Тугчин, Үзөөн зэрэг нитугийн хамнигадыг “Ононы хамнигад” гэх бүгөөд тэдэнд залайр, горлод, үзөөн, сартуул, хатакин, табан (тан), найман (тан), зайдан, дагаанхан, унзал, сонгоол, хашин, балтиаган зэрэг омог бий. Угсаа ястаны кэлэни хамниган монгол аялга болно.

Шилкэ Шита(Чита) хавиар нитугладаг хамнигадыг “Шилкын хамнигад” гэнэ. Тэдэ бүхнөөрөө хамниган монгол кэлтэй ба тэдэний доторхи нигэ хэсэг ни монгол эвенк хоёр кэлтэй, Шилкын хамнигадын нигэ хэсэг ни монгол эвенк кэлийг хамтада ни яридагаараа Ононы хамнигадаас илэрхий илгагдана. Дахивал Ононы хамнигадта байх үгэй чибчин, намиад, дулигад гэх зэрэг омогууд байх юм аа.

МОНГОЛ УГСАА ЯСТАНЫ ХҮМҮҮС

Оросто нигэ үе Ононы, Шилкын хамнигадыг бүхний нилэнхий удаар тунгус угсаатанда багтаж байгсанаа 1962 онд Буряадын эрдэмийн күрээлэнгийн арав гаран эрдэмтэн Онон голоор нитуглажи байсан хамнигадын түүхэ, кэлэ, соёлын орчиндо байцагалт кийж, тэдэнийг «Монгол угсаа ястын хүмүүс» гэдэг дүнгийг гаргаба.

Шинжилгээ судалгааны ажил гүнзэггүйрүүлхийг дагалдан өөрийгөө “эвенк”, “хамниган” гэж хоёр зүйлөөр нэрэлдэг хамнигадыг биеэ зөвхөн “эвенк” гэдэг күмүүстэй ялган үзэх болсон гэж судлагч Арслан Гомбожапов Оросын холбооны улсын шинжлэх ухааны академиин Сибириин түбэй кэлэ бичигийн хүрээлэнгийн ахалагч эрдэмтэн, түүхийн эрдэмийн дэд доктор яригсан билээ.

ЗУГААЛАЙ, НАРИН ТАЛАЧИЙН ХАМНИГАД

Нарин Талача, Зугаалайн хамнигасын ярикаду дээр дурдагсан “Шилкын хамнигад”

гэдэг зэсэ эхилбэл илүү ойлгомжтой болно гэж үзэнэ. Нарин Талачи гэжи лаблагсанд “Нарин” бишэ “Наран” гэх юм аа. Гэбэч, хамнигадын ярианду “Нарин Таалача” гэжи гүүлдэг ни соностодог. Бараглахад энэ л нитугийн нэрэ бизэ. Эндэ орос дуудалаг кийгээд, хамнигадын ярианы зарчимын дагуулалт “Нарин Талача” гэж бичибэ. Оросоор “Зугалай” хэмээн бичисэн нэрийг мүн лэ хамниган кэлэ ярианы онцлогоор “Зугалай” гэжи бичикэд чи орос бичилгтэй дуудалга нигэ болба.

(Д.Г.Дамдинов «Тала-ца» (тала, талаты газар) гээд тайлбарласан байдаг. Редакторын ажиглалт)

ШИЛКЭ ГЭДЭГ НИ ГОЛЫН НЭР

Хэнтий нирууны зүүн бэлээс эхи авсан Онон гол зүүн хойшоо урдаж Ингата голтой нийлж Шилкэ нэрэтэй болоод, зүүн хойшоо урдасаар Эргүнэ голдо цутгадаг билээ. Эргүнэ гол зүүлэн Кара мурэнд (Амур) чухадаг. Хамнигад маши дээр үеэсээ Онон, Шилкэ, Эргүнэ голын сава нитугаар нүүдлэн аж түрэгсөөр иржээ. Хамнигадын нитугласаар ирсэн Боорж, Үрэлэнгэ, Түүргэ зэргэ ни мүн лэ дээрхи томо гол мурэнүүдтэй урасхал нийлдэг арай бага шиг голнууд болно. Бооржи гол Шилкэд нийлж, Эргүнэ голдо хүрнэ. Үрэлэнгийн гол ни Бооржийн зүүн биеэр урдадаг байна.

Шилкын хамнигасын суугаа нитугаар ни Шилкын Таалачи (Талацууд), Нарин Талаца, Дэлигүн хамниган, Хара-Шивэр, Зугалай, Цагаан Уул – Агаар байдаг хамнигад, “Бооржи Түүргийн хамнигад” Түүргэ гэдэг ни голын нэрэ “зүүн хамнигад” гэхэ зэргээр кэлдэг байна. Шилкын хамнигадын нигэ хэсэг ни эвенкүүдийн зарим аймаг бүлэгүүдтэй худхалдан, ижилшиж нигэ угсаа ястан болж бүрилдэсэн түүхэтэй. Хамнигад ба эвенк күмүүсийн нийлэн ижилшэх хугасаа ни наада захадаа хэдэн зуун жил үргэлжилжээ гэж үзэнэ.



ОРОС УЛСЫН ХАМНИГАДЫН АМЬДАРЧ БУЙ НИТУГААР АЯЛАГСАН ТЭМДЭГЛЭЛ



Монгол Уласт “Шилкын хамнигадта” багтах хамнигад олон байгсани академич Б. Ринчины “Монгол ард улсын хамниган аялгуу” гэдэг ганц сэдэбэтэ бүтээлээс мэдэгдэнэ. Хөлөн Буйрын Хуучин Барга хушууны эвенк үндэстэн ни сум кийгээд эвенк үндэстэни үбэрдэгэн засах хушууны Шинэхээн нитугту байгаа хамнигад ни цүм Шилкын хамнигадын күрээнд ороно. Тэдний суугаа нитугийн нэрээр «Мэргэлийн хамнигад», «Шинэхээний хамнигад» гээд хубаан нэрлэдэг.

Дээр зууны эхин үед Шилкын хамнигад голдуу Үрэлэнгэ, Талаца, Бооржи, Түүргэ гээд төмөр зам дагуу нитугаар нүүдэл, суурижил хоёрыг хамтадган малжиж байба. Хаанта Оросын дотоодын дайн дажин кезд нийгэмийн үймөөн дабалгаа ни хамнигадай нитугта хүрэгснөөс тэдний нигэ хэсэг ни тус бүри Дундаду (Хитад) улс болон Монгол улсын хилийг нүүдлөөр дабан оржу сууришигдсан билээ. Даширамд дурадха ни хамнигадын эрт

дээр үеэсээ нүүдэллэн ажу түрсөөр ирсэн газар ороны хүрээ хэмжээни нигэ хэсэг ни Хитад–Орос болон нүгөө хэсэг ни Орос–Монголын хилийн уулзуур хубийн нитуг болоно. Онон, Эргүнэ зэрэг голын сава нитугаар нүүдэллэдэг ба уул мурэн голын нигэ хэсэг ни Орос, Монгол, Хитад улсын хилийн заха юм аа.

АГЫН ХАМНИГАН НАСТАН ШИРАБ НИМБУ

Агын хамниган настан Ширав Нимбу (2011 онду 70 настай) Хандагай ураатай сартуул омогтойгоос: Дээр зууны 50 гаруй онду жижиг шилээны (сэлээн) нигэдэхэд Дэлигүн хамниган нигэ нийлэжи дахин салба. Дэлигүн шилээнд 1958 он хүртэл табяад үрхэ хамнигад байба. 1959 (зарим настай ни 1958 он гэнэ) онд наашаа Кара–Шибэр, Зугаалай зэргэд нүүж ирбэ. Зугаалайд орос эхнэртэй хамниган олон байдаг. Дэлигүн хамниганд орос нэртэй хүмүүс олон. Шилкын хамнигад



ХЭНТИЙ НИРУУНЫ ЗҮҮН БЭЛЭЭС ЭХИ АВСАН ОНОН ГОЛ ЗҮҮН ХОЙШОО УРДАЖ ИНГАТА ГОЛТОЙ НИЙЛЖ ШИЛКЭ НЭРЭТЭЙ БОЛООД, ЗҮҮН ХОЙШОО УРДАСААР ЭРГҮНЭ ГОЛДО ЦУТГАДАГ БИЛЭЭ. ЭРГҮНЭ ГОЛ ЗҮҮЛЭН КАРА МҮРЭНД (АМУР) ЧУДХАДАГ. ХАМНИГАД МАШИ ДЭЭР ҮЕЭСЭЭ ОНОН, ШИЛКЭ, ЭРГҮНЭ ГОЛЫН САВА НИТУГААР НҮҮДЛЭН АЖ ТҮРЭГСӨӨР ИРЖЭЭ.



биеэ эвенк гэжи кэлдэг үгэй.

Хубисхалын сүүлээр 1917 оноос хойш хамниган үндэстэн гэжи байхгүй “эвенк” бий гэгсэнд “эвенк” гэжи бичих болжээ. Түүнөөс хойш мүнөө хүртэл “эвенк” гэжи бичигсээр байна. Ононы хамнигадыг “буряад” гэж бичдэг гэбэ. Ширав Нимбу настаны аба ни хамниган монголоор яридаг бүгөөд эвенкээрч мэдэдэг байгсан. Абу эжий ни оротон эвенк ба экэ удаган байгсан гэнэ.

ЗУГААЛАЙН БА МЭРГЭЭЛИЙН ХАМНИГАДЫН НЭГЭН ЯРИА

2011 оны намар Агын тойрого хавийн нитугаар хамнигадыг эрин сурвалжилж байгаа үеэр Могойтын аймагай Зугаалай сомонд хоёр гудамжа хамнигад байсан гэхэ чимээ соносч уул газарта хүрэгсэн билээ. Цагийн хараагаас ганцакан айлду күрэжи, Цэрэмжид гэдэг настантай хэдэн цагийн ярилсаа кийсэн байба. Цэрэмжид (2011 онду 75 настай) настантай уулзахын тэрэ алдад машита баярлагсан явдал гэбэл настаны яриа ни Мэргэлийн хамнигадтай эгээ адалихан байба. Бутарж тасарсан ааса хойши зуу шихам жил үнгэрч байхад кэлэ яриагаараа (аялгаараа) үчүүхэнч зүрх үгэй байгаа ни тонч баярт учир юм сан. Настан ааса ярихдаа, Зугаалайн хамнигад ни 1958 онду 28 хамниган айл Шилкээс нүүж ирвэ. 28 үркэ ни бага холимог байсанч олонхи ни хамниган хүмүүс байжээ. Би ноён дулигад омогтой, үбгэн мини Нарин Талацын хамниган, хандагай мэргэн сартуул омогтой зургаан күүгэдтэй, нигэ хүбүүн, табан бацагантай. 3 бацагад ман буряадын бэри, нигэ басаган ни оросой бэри, баса нигэ ни хамниганай бэри гээд, Зугаалын хамнигадын залуу багачууд ни юрэнхийдөө хамниган кэлээр ярих үгэй болбо гэсэн билээ. Энэ ни кэдий май ганца гэрийн байдал байгсанч оросын хамнигадын (онсогойлон Шилкын хамнигады) үнэн байдалыг түлэблэж байгаа юм аа. Тиймээс настаны ярианаас оросын хамнигад буряад буюу оросчуудтай худхалдан суухын дунд тэдний өөрийн ни кэлэ, соёл ни хайлан балархайшаар ирсэн ябасные муулан ойлгож болно.

Зугаалайд хоёр гудамжа хамнигадтай бөгөөд 2011 онд олон хүмүүстэй уулзаж амжигсан үгүйгөө нөөнэ гэдэг бодолоор 2019 оны зун дахин хүрэгсэн билээ.

Хамагын түрүүн Цырэмжид настантайгаа л золгожи дээр удаагийн ярилцаа тонч дутаху болсон харамсалаа нөөхийг зорибоби. Настан тагаалал болоод хэдэн жил үнгэрөө гэсэн чимээг соносч, гашуудал харамсалын мананда дүтэхэнэ бүрхөөгдэбэ.

Настаны нигэ захиа байгса ни биелүүлхийг оролдогсон боловч чидагүй байжээ. Юу гэвэл, настны эжийн ни эгэчи (Цырэмжид настанду нагаса эгэчи болно) нүкэртэйгөө хоюулаа үймөөний үед буряад хамнигантай суугаад Хитад уласт нүүбэ. Эгэчи ни нүкэр (хуряахай, хүригэн ни) Мигүлгэ гэдэг нэртэй. Тэдний үрэ изагуурын сурагыг олхыг найдагсан байва. Мэргэлийн хамнигадын дээр үеийнхинд тиймэ айл байгсан сурагыг ологсон үгэй тул Шинэхээн нитугт ла байсан бизэ гэжэ таамаглаба. Танил хүмүүсээр дамжуулан сураглагсан боловч тодорхой харюу олоо үгүй байгсаар хамнигадын ойрын нигэ–хоёр зуун жилийн түүхэ соёл ни настаны цээжинд амидий хэвээрээ хадагалагдаж байдаг хойшийн үеийнхинч ни амжин цуглуулах үгэй лэ юм бол бичиг номд байхгүй үндэстэний өвөө ара араас ни алдаад байха болно.

“БИДЭНҮҮД ХЭНЧ БОЛХООЧ МЭДХЭЭ БОЛИГСАН ГЭСЭН”

Үнгэрэгч зун (2019 онд) байцаган сурбалжилах хүрээ хэмжээгээ дэлэж, Шилкын хамнигадын түблэрж байгаа нитугийн нигэ болхо Карымска аймагын Нарин Талацаду күрвэ. Бидэнэр Өвөр Байгалын кизгаарт багтах хамнигадыг сурвалжилхаар ябахудаа, Дарима багши (дулигад омогтой) Улаан–Үдэ хотоду монгол бичигийн “Тэнгэрийн бичиг” ниигэмлигийн даргатай цуг явава. Тэрэ өөрийн дээдэ үеийнхиний нитугаар ябаху зорилтотой байсан тула бидэнд замчилхын цацуу кэлэмэрчилвэ. Дарима багшийн өөрийн бие ни Шилкын хамнигадта багтадаг ааса тухайн нитугуудаар уул ни удам угсаагаа хайхаар явж үнгэргэгсэн гэнэ. Тиймээс газарын байца кийгээд хүн зоны байдлийг экэ нарин л мэдэж байжээ. Хамнигадынгаа гарал үүсэл, угсаа гарвалыг сайн мэдэхийн үүднээс холбогдол бүхий ном бичигүүдийг олон уншигсан бөгөөд Шилкын хамнигад гэдэг тухай нарилиг ойлголтоотой болсон байжээ. Хамнигадын орчимдо зоог дэлгэвэл бид хоёрын яриа екэл нэгэдэлтэй болж



байдаг ни цум Шилкын хамнигад байхын учир гэжи ойлгодог.

Нарин Талаца сомоны захад хүрч нигэ жижэг дэлгүүр эрхилж байгаа хүмүүстэй уулзаж хамнигадыг сураглахад өөрийнгөө бие мүнч хамниган гэсэн бүгөөд бидэний дүтэжнэ нигэ айлд дагуулан очива. Нарин Талацын хамнигад уул ни мал малчин нүүдэллэдэг байсан дурасхалийг хадагалж байгаа. Бидэнтэй уулзажа ярилцаглан Нарин Талацын хамнигадта хамниган кэлээрээ яридаг хүн нэгч байгсан үгэй. Цүм оросоор яриж байв. Тэдний заримни ганца ниг холбоо үгэ хэлж байха ни хамниган ярианы аялга гэдэг ни тодохон мэдэгдэжи байсан билээ. Нарин Талацын хамнигадтай анх уулзахад, «Биднүүд хэнч болхооч мэдхээ болигсан гэсэн». Тэдний дуралдалда хамнигадын түүхэ соёлду холбогдолтой зүйлүүд баймаар асуугдал өгүхүлнэ. Тэдний гэрээсээ авчиран үзүүлсэн гэрэл зурагуудын хүмүүсийн чирай ни хаанасаа ни харсанч хамниган хүмүүс байха ни тодохон. Сурвалжилгаа хүлээсэн хамнигадуудыг ажиглахад заримуудынх ни чирайду орос чусутны чус холигдогсон шинж тэмдэг элрхий.

Нарин Талаца ба Зугаалайн хамнигад үнгэрэгсэн зун Дэлигүн гэсэн газарт очиж, нитагынгаа овоо такигсан гэгцэгэжи байв. Үүнээс тэд өөрийнгөө нитуг ус, удам гаралынгаа тухай нарийн мэдэж л байх түлэбтэй. Тэхлээр Шилкын хамнигадын адали бишийн цаг хугацаанд өөрийгөө «эвенк», «тунгус», «буряад», «орос» гэхчилэн тэмдэглүүлж байгаасаа ни нийгэм түүхийн нүхэцэл бололцоогоос шилтагаалагдасан бизэ гэжи үзэнэ.

ГАН ТҮМЭР ТҮШЭМЭЛ

Шилкын хамнигадыг ярикудаа Ган Түмэр

түшэмэлийг тоорижо гарахын арга үгэй. Учир ни 17 дугаар зууны жилийн дундач үед (1654 он гэдэг) Ган Түмэр түшэмэл оросчуудын түрмгийг ажиллагаанд дура үгэйцэн харьяат арад зоныгоо дагуулан (Шилкын хамнигад багтана) Эргүнэ гурван гол (Гвэн, Хабул, Далбур), Хайлар гол Дагу нитугаар 10 гаруй жил нүүдэлбэ. Тус түүкэ явдалаас хойш хамнигадын дунд “Гвэн уруудагсан Ган Түмэр” гэдэг хэлэлгэ буй болжээ. Гвэн гол ба Гвэн Түмэр гэх хоёр нэр нягта холбогдолтой юм.

Ган Түмэр түшэмэл хожим ни Манжийн хаантайгааралцахаа болижуул нитугаа буцаж Оросын хааны харьяанду оробо. Ган Түмэр түшэмэлийг хамниган хүмүүн, эвенк хүмүүн, дагуур хүмүүн гэж адали бишээр яриха ни буй. Ямар байгсанчи Шилкын хамнигад бол Ган Түмэр түшэмэлийн харьяанда ябагсан хүмүүстэ багтана. Хамнигасын дунд томохон бүри байрыг эзлэх дулигаад омог ни даруй Ган Түмэр түшэмэлтэй холбогдолтой. Үүний уламаас дулигад, ноён дулигад, Ган Түмэр дулигад, ачиг цагаан дулигад, хаян дулигад, монгочээн дулигад, чимчигэн дулигад, үлдэгүн дулигад, намнагад дулигад, баягид дулигад зэрэг дулигадтай холбогдолтой омогууд байдаг бөгөөд дулигад, ноён дулигад зэрэг омог ни хамгийн үргэн хэмжээнд тарагсан билээ.

ХУРАЛГА НИТУГИЙХИНИЙ ХАМНИГАН КЭЛЭ

Хуралга бол Акшаагын аймагын нигэ сум болно. Хуралгын засаг дарга Сариева Манидари дарга хамниган үгэнүүдийг эмхидхээд хэллэхэд бэлдэгж байгаа чимээг сонсоод яг лэ эрил болж ябаа зүйлөө бөөнөөр ологсон шиг баярлагсан юм сан.

Хуралга гэж голын нэр болно.

Сариева Манидари даргаас орос галигийг ашиглан тэмдэглэж байгаа хамниган үгэсийг эмхидхээд бидэнд үзүүлбэ. Хамниган үгэсийг эмхидхэхийн цацуу хамнигадын хэрэглэдэг хабату үгэ, зүйр цэцэн үгэ зэрэг хэбшэмэл хэлэлгийг цуглуулж байна гэсэн байна. Манидари даргын хэлэгсэн ёсоор, түүний галигласан хэсэг хамниган үгэсийг дахинд хэлүүлэн Хуралгын хамнигадын кэлэ ярианы үбэрмэцэ талуудыг ихэвчилэн ойлгож авлаа. Энд хуриангуй дуралбал, Хуралгын хамниган кэлэ яриа ни мэргээлийн хамнигадтай тон ойр.

Баруулжаа Тарбалжа, Куралга, Алтан зэрэг нитугуудын хамнигадыг «Ононы дээдэхи хамнигад» гэж хэлдэг. Тарбалжа гэдэг ни голын нэрээс ирэлтэй. Тарбалжа ни хамниган нитуг, экэнхи ни хамнигад бүгөөд Шилкын хамнигадын нигэ хэсэг ни Тарбалжаар Монголын хил даваж, үлдэгсэн ни мүн уул нитугта сурилжээ.

2010 оны зун Монголын Дорнод аймагийн Буян Уул сумын харьяат хамниган ястан настан Жабтай уулзахад, “Дээд үеийнкин ни Тарбалжа, Нарасун, Онгоцоон зэрэг нитугийн хамнигадыг хамниган монгол кэлэ ярианд мэргээлийн хамнигадын кэлэ ярианы онцлог илэрхий мэдэгдэнэ.

ТУГЧИН ХАМНИГАД

Тугчин, Гүнээкин хамнигадыг зарим эрдэмтэн эртний урианхай аймагийнкин гэдэг байна. Зарим омогийнки ни Галдан Бочигтын цэригийн тасархай гэдэг.

“Тугчин” гэдэг үгэ хамнигадын нигэ омог байж, уул омог Монгол Улсын Дорнод аймагийн Дашбалбар, Баян Уул, Булаган, Цагаан Овоо зэрэг сомонуудта болон Завхан, Дорнод халх монголчуудын дунд

байгааг академичи Б. Ринчен бүридгэжээ, “Чингисын үед туг бариха цэргийн хүмүүс тугчин гэж бусдаасаа онцоор туг саких үүргэтэй байгсанаар омогийн нэрэ болж, хожом туг үгэй болгосончи Тугчин нэрэ ни үр саданда ни омог болжо үлдэгсэн” гэдэг гэбэ.

Тугчины түүхээс: 1640 онд Мани, Могда ака дүү хоёр Монголоос нүүж Ононы хойто биедэ Үгөөмэр уулад (Тугчин сомоны баруун тээ ни оршин байдаг) хоногсоноос Мани энэ нитугт үлдэж, Могда ни хойшоо очива гэдэг. Мани гэдэгийн омог хатакин табан гэж нэрлэгдэнэ.

1663 онд Тугчин хамнигад Ган Түмэр хааны цэригт орж, килийн харуул болжээ.

Тугчинда табантан, унзал, дагаанхан, зайдан, наймантан зэрэг 5 омог байдаг. Сүүлийн үед агаалай, залайр омогийн Үзөөнөөс нүүн ирээд, нийтэ 7 омог болбо. Тугчиныкин Мүнх тэнгэри, Цагаан үбэгэнийн шүтэдэг.

ГҮНЭЭКИН ХАСАГ ХАМНИГАД

Гүнээ гэдэг ни хамниган омогийн нэрэ байж, уул омог “Гүнээкин” гэжэ дуудалгаар Монгол улсын Дорнод аймагийн Дашбалбар, Булаган, Баян Уул, Цагаан Овоо сомонуудта, Увс аймагийн Баядын дунда байна гэж академичи Б. Ринчин бүридгэв.

“Гүнээкин” гэдэг бол екэ цэрэгийн жагсаалда гүндэ ни ябадаг байртай учир Гүнээкин гэж нэрэтэй байгсаар, тэрэ ни даруй овог болж, одоо хүртэл үр садан ни биеийгээ “Гүнээкин” гэдэг үбэгэ эцэгэсийн домогтой гэдэг байна. Гүнээдэ балтиаган, сонгоол, сартуул, хашин, залайр, зайдан, соохор, цахар омогууд бий. Гүнээкин ба Ган Түмэр хааны хамнигад Орос гүрэний хасаг цэрэгийн бүри-дхэлд орж, Оросын килэ сакидаг харуул болбо.

ХАСАГ ХАМНИГАН ГЭДЭГ ҮГЭ ҮҮНЭЭС ЭХИТЭЙ

1758 онд икэ зуд болж, мал унаа икэ сүйдч, хамнигадын байдал хэцүү бологсоноос килийн харуулын үүрэг орос хасагуудта тушаав. Тийгээд гүнээкин одоогийн нитугтаа нүүн ирж, 1802 онд модоор дацан бодхов. Тэрэ ни Өвөр Байгалын кизаарт түрүүчийн дацан гэж тоологдог.

Ж.Сэндэм, Өвөр Монголын өөртөө засах хороны Хөлөн Буйр дээд сургуулийн багши, профессор. Энэ тэмдэглэлийг Любовь Загдаева монгол бичигээс хөрвүүлэв.

БУРХАН ШАЖИНТАЙ ХАМНИГАД

Хамниган угсаатан 5 дугаар зуун жилдэ тон түрүүлэн бурхан шажинда орожи экилээ. Китадта Оросой элчин сайд асан Иакинф Бичурин Мангууд хадада олдосон 2 бичиг олосон юмэ. Тэрэ хоёр бичигий ни Китадай хуучин дацанда хадагалагдажи байгаа. 5 дугаар зууны жилдэ монголчууд (тоба) Онон голду Мангууд күндийдэ агуй малтажи, өөсдийн уг удамдаа дурсалга кидэг байгаа. Тэрэ агуйн амусартаки чилуунда табан ондоо бичигээр мүргэлийн тарнинуусыг тоншижи сийлээтэй. Түрүүчийн хамниган кэлээр бичээтэй тарнийги уйгаржин гэжи

мэргэжилтэнгүүд буруу тайлбарилдаг. Кидан гүрэний Үрилэнгийн, Киркирийн балгасун суурингуудын дацангуудын күцөө чилуунда бичимэл ни хамниган бичигтэй мүнөө Санкт-Петербургда байдаг. Кидангууд 10 дугаар зуун жилэй экиндэ буддын шажинда оросон билээ. Үрилэнгийн, Киркирийн балгасун (городнице) барижи түбкинэжи байсан.

Тэрэ Кидангуудын цагааса хойши буркан шажины тарнинууд тараа асан. Онон голын хамнигас тон түрүүчийн ичигий гэр дугангуудта мүргэл кидэг байсан.

Оросой гүрэний Сибирийн газар эзлэхээс

кээзэни урида буркантай, буян мэдэдэг эндэки күнгүүд болбосоролтой байсан. Бөөгэй дурдалга тоохоо болихой байгаа. Буряадуудай Байгалай баруунааса ирэхэдэ ни бөөнүүдөө хори буряадуудта тусаламжаар элигээдэжи экилээ.

Онон голын хамнигад зоноороо үцөөн л аад, зургаан дацантай байгаа: Гүнэйн (1801 он), Тугчины (1802 он), Хужиртын (1828 он), Бэрцийн (1828 он), Тарбагатайн (1828 он), Күшүүрийн (Улхуны, 1832 он). Эдэ модоор баригдасан дацангууд байсан.

1930 онуудаар Зүлэлтэ засагийн

зарлигаар дацан кийдүүд булта хаагдаа асан. Мүргэл ябуулагчидасаа ганца нэгэ күн үлэсэн байху. Эцэгийн дайнааса хойши дацан дуган нээгдэжи экилээ асан.

Мүргэл бол күн зоны сэдикэл, ухаан бодол тэгширүүлэн, утагийги ни ойлгоху гэечи этигэлийн дээжи болуно. Санаан тэгширбэ лэ үйлэ кэрэгий ни бүтээтэй, юумэн бүкэндү найдажи өөрийгөө муу сайниги ойлгодог болоху, юумэндэ этигэжи ябаху аргагүй утга чинартай.

Дашинама Дамдинов. «Хамниган ярианы, бичигийн кэлэ» номоос



Любовь Загдаева

ТУГЧИНЫКИН

Түгчины зон огсом өөрэ
Түргэдүүч гэжэ зарим нэгэн
Кэн мэдээв үнэн дээрээ
Кэн зосоокий ни нээжи хараав
Хамниган гарбалтай күнийг
Хамар дээрээ цухалийни гэжэ
Ханилжи сэтгилийни нээгээ аас
Хорогүй цэкэ зон байха

Угаа усанда хаяа үгүй
Урма зоригоо мүхөө үгүй
Ажилдаа амжилтатой
Амгулан тэгши байдалтай
Урагшаа ходо санаатай
Урдач бэркэ зантай
Утахан Ононы эрьедэ
Хамниган улад суудаг юма.

Шинэ дуу

ТООНТОДОО МҮРГЭНЭБ

Үг: Любовь Загдаева
Хүг: Ринчин-Ханда Лубсанова

Күний бие оложо төрөөд
Күрисэтэ дэлэкэй дээрэкэнү
Мүнгөнкөн шүүдэрийг умбужи
Мүргэн ябуна тоонтодоо
Дакилта:
Олон жилэ очикод
Онцо мэдэрэ л зорижу,
Энээкэн насны ман од заяа –
Оюукон бодолын ман эрчи күчи

Эжилэн үгэй сэдкэлээ уяраажи
Эльдинкэн тоонто газараа
Элигэлэн тэбэрин күльбэрэкү –
Ямар икэкэн буяун бэ
Дакилта:
Олон жилэ очикод
Онцо мэдэрэ л зорижу,
Энээкэн насны ман од заяа –
Оюукон бодолын ман эрчи күчи

Колын хари газар ааса
Калуун зүрэкөөр тэгүүлэн
Эжий абын буяунтай
Эрдэни заяатай нитуг мини.
Дакилта:
Олон жилэ очикод
Онцо мэдэрэ л зорижу,
Энээкэн насны ман од заяа –
Оюукон бодолын ман эрчи күчи

БЭРЦИЙН ГОЛ

Кабтугайкан Бэрцийгөө үгсүүлөөд
Казаартуканаа зобоогоод табарнаакучидөө
Канилаад намакантай ябуку үгэй аад
Карункуйгаар ирүнөөкү чини каширтайдөө

Үргүнкөн Бэрцийгөө үгсүүлөөд
Үриэкүнөө зобоогоод табарнаакучидөө
Үргүлжи намакантай канилаку үгэй аад
Үдөши бүриирнөөкү чини залкуутайдөө

Уртукан Бэрцийгөө үгсүүлөөд
Унугчийгаа зобоогоод табарнаакучидөө
Учираад намакантай ябуку үгэй аад
Уулзакоо ирөнөөкү чини залкуутайдөө

**АРДЫН ДУУ**

Алтан дэлэкэйн уужим дөө
Ардаг ябууаха морин юу мөө,
Абу эжийн буян дөө
Айдар ябууаха биеэ юүмөө
Энээкэн дэлэкэйн уужим дөө
Эмниг ябууаха морин юу мөө
Эжийн абын буян дөө
Эркэл ябууаха биеэ юүмөө
Нитуг нугуын айкан дөө
Номогон урааха морин юу мөө
Нүкөд зонькез өргөмжи дөө
Нандин ябууаха биеэ юүмөө

АРДЫН ДУУ

Шилөөһөний идөөцөөн шингэн күбчин оёртоо
Шинии минии зугааны ширэмэн танкын карюулга
Калюуны идөөцөөн кара л талын оёртоо
Камуг зоны зугааны кадамал танкын карюулга
Булааганы идөөцөөн буурал күбчин оёртоо
Булта л зоны зугааны мотомол танкын карюулга
Өнөөгөний идөөцөөн өргөн шира л таладоо
Өетөн зоны зугааны өетий л танкын карюулга.

АМРАГКАН ГАНЦА МИНИ

Урдуураа Онон моно зурйгааг
Улигам түргэнөөр урсанал даа
Үнинэй намайгаа күлээнэл гөөд
Уяран байнал дөө, амрагкан ганц мини
Хойгуураа Онон моно зурйгааг
Хурдан түргэнөөр урсанал дөө,
Хододоол чамайканаа күлээнэл гөөд
Хүндэлжи угтана л дөө, амрагкан ганца мини.

ИЖИЙ АБУ КОЁР МИНИ

Бадмакан лёнхобо бадаранкай
Баянкан цагаан Онон гол мини
Бага күүгэдкэнээс мини санагданкай
Бууралкан ижий абу коёр мини
Конхокон лёнхобо бадаранкай
Кабтагай цагаан Онон гол мини
Хододоол санаанди мини санагданкай
Күндэтэ ижий абу коёр мини
Улаалзай лёнхобо бадаранкай
Уртакан цагаан Онон гол мини
Укаандам үргэлжил санагданкай
Уякан сэткелтэй ижий абу мини

СӨЛӨНГЭЙ ТАТУУРГА

Сөлөнгэйн татуурга ни гүнзгийч ааса
Сайбаркан боры мини койлойгоор ни
Сэтгилтэй нүкүд олон ч ааса
Шилисэн ганцадам күрэнгүй дө
Ононой татуурга ни гүнзгийч ааса
Оодонкон боры мини күзүүгөөр ни
Олонкон нүкэд олон ч ааса
Онцолсон ганцадам күрэнгүй дө
Карагай татуурга ни гүнзгийч ааса
Каракан көөрий мини койлойгоор
Канилмаар нүкүд олончиги ааса
Кайратайкан ганцдам күрэнгүй дөө

ГЭКЭ Л ГӨӨ БИЙ

Хадыгаа дабуулкамануг гэжил байн л дөө
Хазаартайминчи такагүй гэжэ л гөө бий
Канилаж коюулаа суукамануг гэжил байнл дөө
Каажуудаа нүкэртэйби, яакач күнбийч
Уулыгаа дабуулкамануг гэжил байнл дөө
Унагчимчи такагүй гэжэ л гөө бий
Учиркамануг коюулаа гэжил байнл дөө
Учирсан ганцатайби, яакач күнбийч.

Хамниган угсаатны ёсу заншил, өбү соёулыг
сэргээн мандаакын төлөгөө зүтгигч, эркэм күндэтэ
нитугийн акай
Санжэйгийн Мүнкэжиргал танду өргөн баримой.



“Зүркэндэ коногших дагуун (дуун) еврөөлийг
Зүүдэнээс сэрсэн Хамниган түмэндээ зоригулжа
Ононы шигүйд очисонби кэмээн бисалган
бичээсэмбэ
Он онду дуулагдаж байтгайна гэжэ зүркинээсээ
бичимой...”

Шүлгийг ни МЗЭ-ийн шигналт ирагуу найрагчи
Д.Ган-Очир
Аялагууг ни Урлагийн гавьяат зүтгэлтин, күгжимийн
зохиолчи Г.Энхбаяр

ХАМНИГАДАА ЕЭРӨӨӨ

Буркан Калдундаа мөргөжи
Буурал түүкээс наашилсан
Эртөний изгуурт Хамнигад мини
Эргэн нийлөөд дуулалдажи байна биде
Дэлүүн Болдогоо дээдэлжи
Дээд угсаагаа киөсөөр (көөсөөр)
Ончирчи нэгдэк Хамнигад моно
Ононгийн эргээсээ дуулжи байна биде
Дахилт:
Дуба сокур, Добу мэргинээс улбагаатай
Догшин жиунуудта (зуунуудад) ассун галаа шитүсэн
Наран, сарангаа тэнгиртэйгөө дээдөлсүн
Нартад ганцкан Хамнигадаа еэрөөө өө
Ононгоо дагужи амидарсан
Оёогун билигтэ Хамнигад моно
Цагаан Тэнгиртөө сүсиглэсэн
Цадиг түүктэй Хамнигад мини
Угсагаа, гарбалаа киөсөөр (көөсөөр)
Уулзак зонууд Хамнигад моно
Агула (уул) , усаа мөдөлцөсөөр
Учиран золгоко Хамнигад мини
Дуба сокур, Добу мэргинээс улбагаатай
Догшин жиунуудта (зуунуудад) ассун галаа шитүсэн
Наран, сарангаа тэнгиртэйгөө дөөдөлсүн
Нартад ганцакан Хамнигадаа еэрөөө
Ниуца Товчионду нуматайгаа
Ниуцлагдан үлдэсэн Хамнигад мини
Цэцө мэргидийн удумтай
Цэклен зогсука Хамнигад мини
Хан Кэнтийн агулас (уулс) ни
Хамнигад түмний аригун голумта
Урсун цутгака Агуц, Улз, Балжу ни
Умдагааны дөөдү аригун ирашаан
Дуба сокур, Добу мэргинээс улбагаатай
Догшин жиунуудта (зуундад) ассун галаа шитүсэн
Наран, сарангаа тэнгиртэйгөө дөөдөлсүн
Нартад ганцакан Хамнигадаа еэрөөө өө



ХАМНИГАН-ОРОС ТОЛЬ

(Зохиогч Д.Г. Дамдинов)

АБА, АБО (Дел.), абу (Алт., Кыра, Тарб., Ул.-Парт., Кур.) | отец, папа; абатана ваш отец; абооһа абаад ацара (Дел.) возьми у отца ипринеси.

АБА, АБУ (Ул.-Парт., Тарб. и др.) || уст. облавная охота; аба хайдаг облавная охота, облава на зверей.

АБААЛДЗАЙ зоол. паук; абаалдзайн шилүсү паутина.

АБААЧИТАЙ 1) хитрый, лукавый, обманчивый; 2) ловкий, шустрый, расторопный, разбитной, бойкий; 3) слово охотливый, красноречивый; кэлэ амандаа абаачитай красноречивый.

АБААЧИХУ 1) брать с собой, уводить, увозить, относить; гэртээ ирэхэдэ мэни күбүүн мини намай абаачихаа ирээби гэбэ когда я пришел домой, мой сын сказал, что приехал увезти меня к себе; уриджи абаачиху пригласить к себе; абаачиджи үкүд оставлять кому-л.; дзаладжи абаачиху увозить к себе; абаачихуйн киридү бацаган

күбүүн хоёр гараба фольк. в момент угона родились сын да дочка; 2) сносить, уносить; үерэй усу манай гэрииги абаачисан байгаа половодье унесло наш дом.

АБАГА, АБАГАЙ дядя, родной дядя (Уз., Токч., Гун.), абага үмбөө родной дядя (Ул.-Парт., Тарб., Манг., Кыра, Алт., Зуг.); абага эгэчи, абага үмбөө (Зуг., Алт., Кыра, Ул.-Парт., Манг., Тарб.) тетя; фольк. гурбан абаганад күрээдлэ ирээбэ фольк. три его дяди тут же подъехали; абагад мэни наанактуй дяд и мои, помогите.

АБАГАЙ 1) сестра; абагай, юнэй түлөө тиигэбэ гээчибүйчи? (Ул.-Парт., Манг., Тарб.) сестра, зачем ты так сделала?; 2) жена старшего брата; Рэгзэд абагай танайда мэндэ күрэгэнэ жена брата Рэгзэд передала вам привет; 3) вежливое обращение к старшим женщинам; Ханда абгай! Тетя Ханда!

АБАЙ: абай халагмэни эх, горе мое.

АБАЛХУ устраивать облавную охоту, травить зверей.

АБАЛЦАХУ 1) обмениваться, принимать или получать, брать друг у друга; 2) брать вместе, совместно с кем-л.; бичиг абалцаху обмениваться письмами; цуг абалца возьмем вместе.

АБАРАЛ, АБАРУУЛ (Алт., Кыра, Тарб., Ул.-Парт., Кур.) рел. 1) прорицание; молитва; 2) спасение, из-бавление, защита; абарал ирэкү просить из-бавления; абаралтуса помощь; абарал тусыгаа өөрөө мэдээрэй фольк. сам знаешь, как оказать помощь.

АБАРГУИ тиски; күүдин цэндэ абарга табяатай байдага сан вукунице стояли установленные тиски.

ХАМНИГАН УГСАГАТНЫ ТУГ СҮЛДЭ



Хамниган угсагатны тугний билэгдэл, утга агуулага, тайлал:

Эртү үеэс Монгол обуг аймагууд өөр өөрсдийн туг, сүлдэсийг бүтэгээн залжи тэгүүнийгээ күндүтгэн, такин шитүжи ирэсэн уламжилалтай билээ.

1990 оноос Монгол улсад нээлттэй нийгэмэ, илэ тоду байдал, олон ургалчи үзэл түгэн дэлгэрчи тэгүүний үрэ дүндэ жижиг этник группуудын угсагатны укамсар сэргэн, уламжилалту ёсу заншил, биет болон биет буса соёлоо сэргээн, түгээн дэлгэрүүлэхэ эрмэлзэл бий болсон энэ цаг үеийн нийтлэгэ чигэ хандлагын дагуу хамниган угсагатны туг сүлдэний загварыг зохиосон болуна.

Хамниган угсагатны туг, сүлдэсний тайлбар:

- Күкэ өнгийг тугны үндсэн дэбсигэр өнгөөр сонгосун ни нүүдэлчид, монгол түмэн мүнкэ күкэ тэнгэрийг эртү дээр үеэс такин шитүжи ирэсэн уламжлалыг,

- Гал ни өнө мөнкөд мандун бадрака билэгдлийг,

- Наран сарун ни орчилон ертөнцийн оршихуйн билэгдэл, мүн арга билэг буюу “угсагатны хубид абга нартайгаа ами ба нэрэ нигэтэй, нагуца нартайгаа наран ба сарун нигэтэй” байжу ургийн садан төрлийн холбогоого эрчимлэн дэгэдэлж

ябукуыг,

- Тугны гурбан сэрээ ни “өнгөрсөн, одогоо, ирээдүй” гурбан цагу дору нигэн туг мэт бату цул, мүн тугны үзүгүр буюу гилбэр ни гаднаас айка аюугул үгүй, дотороо амур амуглантай, түбшин байкын билэгдэл,

- Цагаан өнгөтэй нум ни “сумаа тавиад нумаа нугудаг хулжин заликай, ёсу зүйгүй хүмүүн лугаа буса, аливаа зүйлд чигчи шилуун, илэ цагаан, үнэнчи шидурга зарчмыг эрчимлэн дэгэдлэнэ” мүн эртинээс цэцэ мэргэн харваачид байсныг,

- Дологон ширкэгэ од, нигэ гал ни дологон буркан од хийгээд алтан гадус од юма. Дологон буркан од ни ертөнцийн умарду зүгэ чигийг заагчи алтан гадус одыг олокод чихул үүрэгтэйг жиртэн күн бүкин мэдэхэ билээ. Монголчуудын ертөнцийг үзэхэ үзэлдэ бидэний орчин тойрныг сав хийгээд шимийн ертөнци хэмэгэн нэрлэдэг. “Сав ертөнц” гэдэг ни күн бидэнийгэ агуулж, тэтгэн тэжэгэж байдаг “газар дэлэкий, сансар огторгуй”, тэдгээрийн бүридил байдаг бол “шимийн ертөнц” гэдэг ни “күн түүнчлэн амид амьтан” бүгдийг кэлнэ. Тиймээс орчилон “сав, шимийн ертөнц”-д өнө мөнкөд оюугун билиг хурца, амур амуглантай, энкэ тунка оршикийн билэгдэл агуулсан бөлгөө.

- Орчлон “сав, шимийн ертөнц”-г толидон харака билгийн мэлмий.

II ФЕСТИВАЛЬ КУЛЬТУРЫ И СПОРТА

В августе 2021 года в селе Гунэй Агинского бурятского округа состоится II фестиваль культуры и спорта этнических хамниганов Забайкалья. Данное мероприятие проводится при поддержке Министерства культуры Забайкальского края.

Участники фестиваля: приглашаются хамниганы Забайкалья, Монголии и Внутренней Монголии КНР.

В рамках фестиваля планируется проведение:

- научно-практической конференции по теме «История, этнография, язык и культура хамниганов»;

- конкурс песенно-поэтического и сказительского искусства хамниган;

- выставки национальной одежды, декоративно-прикладного искусства;

- соревнование по стрельбе из лука.

ОНОНЫ ХАМНИГАДЫН НААДАМ-2021



2021 оны август сард Агын аймгийн Гүнээ суманду Өбүр Байгалийн Хамниган угсаатны урлаг, соёлын олон улсын хоёрдугаар нагадам зокион байгуулагдахаар боллоо. Энэхүү нагадам Өбүр Байгалийн Хизгаарын Соёлын Яамуны дэмжилэгтэйгээр зокион байгуулагдаха юма.

Ононы Хамнигадын урлаг, соёлын нагадам-2021:

- “Хамниган угсаатаны түүкэ, экэ сурбалжи, кэлэ, соёул, ажу төрөкө ёсу заншил” гэсэн сэдбээр эрдэм шинжилгөөний курал зохион байгуулагдана;

- Хамниган дуу, шүлэгийн уралдаган болоку ба мэргэжилийн дуучид, сайн дурын уран сайканчи гэсэн төрөл ангилалаар ябугдана;

- Хамнигасын гоёул чимэглэл, бойтиг гутал, малгай, дэгэл кубцасу, эдү кэрэглэлийн

талаарка үзэсгэлэн гарна;

- Эркий мэргэн харваачидын дунда сура харбука тэмцэгэн ябугдана.

ХАМНИГАН СУДЛАЛЫН ТӨВ